МОНГОЛЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ТОГТОЛЦОО

ТҮҮВЭР ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙН ЗААВАР

Боловсруулсан:	Хянасан:	Баталсан:

ЦАХИМ ХУВЬ. ХЭВЛЭМЭЛ ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ БОЛНО.

ХЭВЛЭСЭН ОГНОО: 24.06.2016

ӨӨРЧЛӨЛТ NO : 00
ӨӨРЧИЛСӨН ОГНОО:

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Rev. No	Хуудас. No	Өөрчлөлт оруулах шалтгаан
1			
2			

АГУУЛГА

Sl.	Бүлэг	Хуудас No.
	Өөрчлөлтийн бүртгэл	2
	Агуулга	3
1	Зорилго ба хамрах хүрээ	4
2	Төлөвлөх мэдээлэл	4
3	Түүвэрлэлт	4
	3.1 Аргачлал	5
	3.2 Түүвэрлэлтийн хэмжээ	13
	3.3 Эрсдэл	

ТҮҮВЭР ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГА ЗҮЙН ЗААВАР

1. ЗОРИЛГО БА ХАМРАХ ХҮРЭЭ

Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-аас хамаарах итгэмжлэлийн хүрээ ба янз бүрийн байршлын түүвэрлэлт нь ТҮБ итгэмжлэлийн хүрээндээ чадвартайг зөв батлах ба үнэлэхэд чухал.

Иймээс энэхүү баримт бичиг нь MNAS-ын журам ба байршил, ажиллах хүчин ба итгэмжлэлийн мөчлөгтэй итгэмжлэлийн хүрээний түүвэрлэлтийн онцлог шаардлагаар тодорхойлон ISO/IEC 17011 стандартын 7.5.7; 7.5.8; 7.7.2 ба 7.7.3 бүлгүүдийн шаардлагыг биелүүлэх зорилготой.

Энэ баримт бичгийн хамрах хүрээнд ТҮБ-ын итгэмжлэлийн хамрах хүрээг төлөөлөх түүвэрлэлт мөн техникийн ажилтнуудын төлөөлөх тоог гэрчлэхэд хэрэглэх ба үндсэн ажиллагаа гүйцэтгэх ТҮБ-ын бүх байршлын үнэлгээг багтаасан үнэлгээний үйл явц хамаарна.

Энэ баримт бичгийн зорилго нь ТҮБ-ын итгэмжлэлийн хамрах хүрээнд тохирох төлөөлөх түүвэрлэлтэнд үндэслэн өргөдөл гаргагч бүр ба итгэмжлэгдсэн байгууллагад түүвэр үнэлгээ хийх төлөвлөгөөг MNAS хэрэгжүүлэхийг батлахад оршино.

Энэ баримт бичгийг MNAS-ын итгэмжлэлийн бүх хөтөлбөрт хэрэглэнэ; гэвч Баталгаажуулалтын байгууллагын хүрээг гэрчлэх түүвэрлэлтийг MNAS AG07, AG08-д тодорхойлсон.

2. ТӨЛӨВЛӨХ МЭДЭЭЛЭЛ

2.1 Итгэмжлүүлэхээр өргөдөл гаргагч нь өргөдөлд шаардах бүх мэдээллийг MNAS-д гаргаж өгнө. Түүвэрлэлттэй холбоотой онцлог мэдээлэлд дараах багтана:

a. Итгэмжлүүлэхийг хүсэлт гаргасан байгууллагын үндсэн ажиллагааны талаарх танилцуулга;
b. Итгэмжлүүлэх салбар/параметр/сорилтын тухай нарийвчилсан жагсаалт;
c. Өргөдөл гаргагчийн гарын үсэг зурах эрх бүхий ажилтан (эсхүл байгууллагын гэрчилгээн дээр гарын үсэг нь хүчинтэй байх ажилтан) тэдгээрийн мэргэшил ба туршлагын талаарх мэдээлэл;
d. Итгэмжлүүлэх үндсэн ажиллагааг гүйцэтгэх бүх байршлын нэр ба хаяг;
e. Итгэмжлүүлэх аливаа газар дээрх байршлын ажиллагаа (үйлчлүүлэгчийн байршилд гүйцэтгэх ажил); ба
f. Эмнэлгийн лабораторийн хувьд:
    - Бүх дээжийг цуглуулах байршил ба тэдгээрийн хаягийн жагсаалт;

- Дээж цуглуулах байршил бүрт судаснаас цус авах тоо;

g. Баталгаажуулалтын байгууллагын хувьд-нэг хамрах хүрээний аудиторын жагсаалт

3. ТҮҮВЭРЛЭЛТ

3.1 Аргачлал

3.1.1 Түүвэрлэлтэнд:

a. Үндсэн ажиллагаа явагдах байршлын түүвэрлэлт ба түүвэрлэлт авах санамсаргүй элементийг авч үзэх эдгээр байршлыг сонгох;
b. Итгэмжлэлийн хүрээний түүвэрлэлт; ба
c. Байгууллагын гэрчилгээн дээр гарын үсэг нь хүчинтэй байх ажилтны түүвэрлэлт (ихэнх тохиолдолд "техникийн гарын үсэг" байх нь тохиромжтой) багтана.

3.1.2 Түүвэрлэх байршил

Үндсэн ажиллагаа явагдах дээж цуглуулах байршлыг багтаасан байршлын түүвэрлэлтийг наад зах нь Хүснэгт 1-ын дагуу явуулна.

3.1.2.1 Сонгох байршил

Түүвэрлэлтийн санамсаргүй элементийг авч үзэхгүйгээр сонгох янз бүрийн байршлыг төлөөлөх хүрээнээс хамааран түүвэрлэлтийг дор заасан хүчин зүйлд үндэслэн хэсэгчлэн сонгох ба хэсэгчлэн сонгохгүй.

Түүвэрлэлтийн наад зах нь 25%-ыг санамсаргүй сонгоно.

Үлдэгдлийг үндсэн ажиллагаа явагдах бүх байршлыг багтаасан хүчинтэй гэрчилгээний үед сонгосон байршлуудын дундаас янз бүрийн хэсгээс сонгоно.

3.1.2.2 Байршлын сонголтын 75%-ыг наад зах нь авч үзнэ:

a. Төв оффис ба энэ үйл ажиллагааны газар зүйн тархалт.
b. Тоо, хүрээ, хэмжээ, төвөгшил ба байршлын байрлал.
c. Байршлын удирдлагатай холбогдох төв оффисийн зэрэг (чанарын тогтолцооны бүтэц).
d. Төв оффис ба байршлуудын дотоод аудитын үр дүн.
e. Удирдлагын дүн шинжилгээний үр дүн.
f. Удирдлагын тогтолцооны төвөгшил.
g. Төхөөрөмж ба аргыг ашиглан ажиллах үйл ажиллагааны ялгаа.
h. Үйл ажиллагааны ялгаа, ж. хяналт/сорилт/шалгалт тохируулга/баталгааны салбар, ж: хяналт/сорилт/шалгалт тохируулгын төрөл.
i. Үнэлгээний мөчлөг дэх гүйцэтгэлийн түвшин.
j. Байгууллагад гарсан өөрчлөлтийн цар хүрээ.

k. ТҮБ-ын хяналтын тогтолцоо ба гүйцэтгэлийг хэмжих баталгааны түвшин.

3.1.3 Итгэмжлэлийн хүрээний түүвэрлэлт

Байгууллагын итгэмжлэлийн хүрээний түүвэрлэлтийг наад зах нь **Хүснэгт 1**-ын дагуу явуулна.

3.1.3.1 Сонгосон хүрээг үнэлэх

Түүвэрлэлтийн санамсаргүй элементийг авч үзэхгүйгээр янз бүрийн хамрах хүрээг төлөөлөх хүрээнээс хамааран түүвэрлэлтийг дор заасан хүчин зүйлд үндэслэн хэсэгчлэн сонгох ба хэсэгчлэн сонгохгүй.

Түүвэрлэлтийн наад зах нь 25%-ыг санамсаргүй сонгоно.

Үлдэгдлийг үндсэн ажиллагаа явагдах бүх байршлыг багтаасан хүчинтэй гэрчилгээний үед сонгосон янз бүрийн байршлуудаас сонгоно.

Үлдэгдлийг бүх үндсэн хүрээг багтаасан хүчинтэй гэрчилгээний үед сонгох хүрээний дундаас янз бүрийн хэсгээс сонгоно.

3.1.3.2 Хүрээний сонголтын 75%-ыг наад зах нь авч үзнэ:

a. Холбогдох хугацаанд хүссэн итгэмжлэлийн хүрээний талаар шаардагдах техникийн мэдлэгтэй үнэлгээний багийн гишүүдтэй байна.
b. Үйл ажиллагааны бүх хүрээг төлөөлөх түүвэрлэлтийг итгэмжлэл олгохоос өмнө анхны үнэлгээгээр үнэлнэ.
c. Үнэлгээ бүрт шаардагдах төрөл бүрийн төхөөрөмж эсхүл арга ба цаг хугацааг тооцно.
d. Үйл ажиллагааны бүх хүрээг төлөөлөх түүвэрлэлтийг итгэмжлэлийн мөчлөгт наад зах нь нэг удаа гүйцэтгэсэн байна.
e. ТҮБ-ын Техникийн гарын үсэг зурагчийн ур чадварыг итгэмжлэл олгохоос өмнө үнэлгээний мөчлөгт наад зах нь нэг удаа батална.

3.1.4 Ажилтны түүвэрлэлт

Ажилтны түүвэрлэлтийг наад зах нь Хүснэгт 1-ын дагуу явуулна.

3.1.4.1 Ажилтныг сонгох

Түүвэрлэлтийн санамсаргүй элементийг авч үзэхгүйгээр үнэлгээнээс сонгох янз бүрийн техникийн гарын үсэг зурагч ба бусад ажилтнуудыг төлөөлөх хүрээнээс хамааран түүвэрлэлтийг дор заасан хүчин зүйлд үндэслэн хэсэгчлэн сонгох ба хэсэгчлэн сонгохгүй.

Үнэлгээг хувь хүн эсхүл хоёул гэрчлэх эсхүл босоо үнэлгээгээр гүйцэтгэнэ.

Түүвэрлэлтийн наад зах нь 10 %-ыг санамсаргүй сонгоно.

Үлдэгдлийг бүх техникийн гарын үсэг зурагчийг багтаасан хүчинтэй гэрчилгээний үед сонгох ажилтнууд дундаас сонгоно.

3.1.4.2 Ажилтнуудын 90%-ыг үнэлэхээр шийдсэн тохиолдолд MNAS дараах асуудлуудыг наад зах нь авч үзнэ:

a. Итгэмжлэлийн хуваарь дахь салбар ба ажиллагааны төрөл.
b. Янз бүрийн салбар ба ажиллагааны төрөлд шаардагдах мэргэшил ба туршлагыг багтаасан эдгээр ажиллагааг явуулах ажилтнуудыг сонгох, сургах, удирдах ба хянах ТҮБ-ын журам.
c. ТҮБ-аас явуулах дотоод аудит.
d. Ажилтан ажиллуулах байршил;
e. Аливаа хуулийн шаардлага.
f. Стандартын шаардлагын дагуу мэргэшлийн байдлыг дүгнэх шаардлагатай ажилтнууд.
g. Лабораторийн өөрийн гэрчлэх ажиллагааны үр нөлөөтэй байдал.

3.1.4.3 Үйл ажиллагааны төрлийг үнэлэхээр шийдэхэд дараахийг авч үзнэ:

a. Үйл ажиллагаанд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц ба үйлдвэрийн ялгаа;
b. Хянагч/тохируулгын техникч/судаснаас цус авагчид тавигдах ур чадвар;
c. Аливаа хуулийн шаардлага; ба
d. Стандартын шаардлагын дагуу мэргэшлийн байдлыг дүгнэх шаардлагатай ажилтнууд;

Бүх гарын үсэг зурагчийг үнэлгээний мөчлөгийн явцад үнэлнэ. Хэрэв газар дээрх ажиллагаа нь дүр эсгэн/ярилцахад боломжгүй байвал босоо үнэлгээг авч үзнэ.

3.1.4.4 Аль ажилтныг үнэлэх тухайгаа шийдэхдээ дараах ойлголтыг авч үзнэ:

a. Шинэ ажил эсхүл шинэ удирдлага;
b. Мэргэшил ба туршлага;
c. Байршил;
d. Аливаа хуулийн шаардлага; ба
e. Стандартын шаардлагын дагуу мэргэшлийн байдлыг дүгнэх шаардлагатай ажилтнууд.

3.2 Түүвэрлэлтийн хэмжээ

Хүснэгт 1-д байршил, ажилтан ба итгэмжлэлийн хүрээний түүвэрлэлтийн хэмжээг тодорхойлохыг дор үзүүлнэ.

Хүснэгт 1: Түүвэрлэлтийн хэмжээ тодорхойлох

<table>
<tr><th rowspan="2">Үнэлгээний төрөл</th><th colspan="5">Түүвэрлэлтийн хувь& газар</th></tr>
<tr><th colspan="4">Үндсэн ажиллагаа явагдах байршил (Сансарын эсхүл салбар оффис)</th><th>Хүрээ/Салбар</th><th>Ажилтан (Техникийн гарын үсэг зурагч)</th></tr>
<tr><td rowspan="2">Анхны үнэлгээ</td><td colspan="4" rowspan="2">100% (ISO/IEC 17011 шаардлагын дагуу)</td><td>А.Хүрээ/Салбар/Дэг журам/ Схем (ж. Хими, Микробиологи, Масс Хэмжилзүй)
100%</td><td>А.Хүрээ/Салбар/Дэг журам/ Схем (ж. Хими, Микробиологи, Масс Хэмжилзүй)
100%
(аль болох)</td></tr>
<tr><td>В. Дээрх А-д: Сорилт/Баталгаажуулалт/ Хяналтын үйлчилгээ/ хэмжсэн тоо хэмжээ эсхүл арга хэрэгсэл
100%</td><td>В. Дээрх А-д: Сорилт/Баталгаажуулалт/ Хяналтын үйлчилгээ/ өргөдөл гаргагч бүрийн бүртгэлд 100% дүн шинжилгээ хийх зүйлийн 25%-ийг хэмжсэн тоо хэмжээ эсхүл арга хэрэгсэл</td></tr>
<tr><td rowspan="7">Магадлах хяналтын үнэлгээ</td><td colspan="4">Байршлын дараах тоог багтаасан 100% үндсэн/төв оффис:

Хамгийн бага магадлах хяналт = 0.8√n
n байршлын тоог үзүүлэх дараагийн бүх тоонд ойролцоо</td><td>А. Хүрээ/Салбар/Дэг журам/Схем (ж. Хими, Микробиологи, Масс Хэмжилзүй)
100%</td><td rowspan="7">Ажилтан = 0.6√n гарын үсэг зурагчийн тоог харуулах</td></tr>
<tr><td>n</td><td>Surv</td><td>n</td><td>Surv</td><td rowspan="6">В. Дээрх А-д: Сорилт/Баталгаажуулалт/ Хяналтын үйлчилгээ/ хэмжсэн тоо хэмжээ эсхүл арга хэрэгсэл
100%
Холбогдох эрсдлээс хамаарах хамгийн багадаа 25%</td></tr>
<tr><td>1</td><td>1</td><td>15</td><td>4</td></tr>
<tr><td>2</td><td>2</td><td>25</td><td>4</td></tr>
<tr><td>4</td><td>2</td><td>30</td><td>5</td></tr>
<tr><td>6</td><td>2</td><td>50</td><td>6</td></tr>
<tr><td>10</td><td>3</td><td>100</td><td>8</td></tr>
<tr><td rowspan="2">Давтан үнэлгээ</td><td colspan="4" rowspan="2">100% байршил
Гэвч үнэлгээ явуулах эцсийн хувийг тодорхойлоход сүүлчийн үнэлгээний туршид олж авсан туршлагыг авч үзнэ.</td><td>А.Хүрээ/Салбар/Дэг журам/ Схем (ж. Хими, Микробиологи, Масс Хэмжилзүй)
100%</td><td rowspan="2">Ажилтан = 0.8√n гарын үсэг зурагчийн тоог харуулах</td></tr>
<tr><td>В. Дээрх А-д: Сорилт/Баталгаажуулалт/ Хяналтын үйлчилгээ/ хэмжсэн тоо хэмжээ эсхүл арга хэрэгсэл
Байгууллагын өнгөрсөн гүйцэтгэлийн хамгийн багадаа 75 %</td></tr>
</table>

Ажилтны үнэлгээ	Шинэ байршил 100%	А.Хүрээ/Салбар/Дэг журам/ Схем (ж. Хими, Микробиологи, Масс Хэмжилзүй) 100%	Шинэ гарын үсэг зурагч 100%
		С. Дээрх А-д: Сорилт/Баталгаажуулалт/ Хяналтын үйлчилгээ/ хэмжсэн тоо хэмжээ эсхүл арга хэрэгсэл 100%	

3.3 Эрсдэл

MNAS тогтоосон эрсдлээс хамааран түүвэрлэлтийн хэмжээг ихэсгэж болно.

3.3.1 Эрсдлийн төрөлд дараах багтана:

a. MNAS итгэмжлэлийн шаардлагыг тогтоох эсхүл улс төрийн эсхүл аюулгүй байдлын шалтгааныг тогтоохдоо чухал эрсдэлтэй газрыг үзүүлэн тогтоох бүс нутаг эсхүл улсад явуулах үйл ажиллагаа;
b. MNAS-ын судалгаа хийсэн албан ёсны гомдлыг авч үзэх;
c. Итгэмжлэлийн шаардлагыг муу хэрэгжүүлсэн түүхтэй байх;
d. Байршил дээр гүйцэтгэх үндсэн ажиллагааг шинэчлэх;
e. Тэдгээрийн байршлыг багтаасан байгууллагаар залруулах ажиллагааг муу хэрэгжүүлсэн байх
f. Итгэмжлэгдсэн байгууллагад гарын үсэг зурагч эсхүл хянагч буцаж очих.